

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцана уу.

- Энэхүү хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэгийг сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.
- Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
- 1-13 дугаар даалгаврыг эхийн утга санаатай холбон ажиллаарай.

Сэтгэлийн хүч (эсээ)

Хүч чадал гэхэд биеийн хүч, тамир тэнхээ л нэн түрүүнд яригддаг. Хүнд байдаг илүү их хүч бол сэтгэлийн тэнхээ. Монголчууд “Биеийн бөхөөр ганцыг дийлнэ, сэтгэлийн бөхөөр мянгыг дийлнэ” гэж хэлэлцдэг. Сэтгэлд хүч тэнхээ, хурд, шид, нууц агуулагдаж байдаг нь маргаангүй үнэн. Түүнийгээ ашиглавал хүндийг өргөж, хэцүүг давж, өвчнийг тэсвэрлэн эдгэрч чадна. Харин хатгүй бол үг даахгүй санаагаар унахаас эхлээд бэрхээс шантарч, амьдралд сөхөрдөг.

Сэтгэлийн хүчээ зөв залж чадвал, гараар бариагүйг барьж, нүдээр үзээгүйг үзэж, хамраар үнэрлээгүйг үнэрлэж, чихээр сонсоогүйг сонсож чадна. Хүчтэй сэтгэл нь юуг ч хийнэ, бүтээнэ, дийлнэ. Иймээс сэтгэлийн хүчийг жингийн туухайгаар хэмжиж боломгүй. “Сэтгэлд гал байвал зууханд гал олдоно” хэмээн М.Цэдэндорж найрагчийн бичсэнээр илч дулаантай, гэрэл гэгээтэй сэтгэл нарны цацрагтай адил. Харин санаа тогтворгүй, үлбэгэр, харимхай сэтгэлээс ажлын бүтээмж үл гарна. Сэтгэлийн бядгүй бол буруу муу үйлд өртөх нь ч бий, муу үйл хийх нь ч бий. Бурхны шашны үзэл номлолоор хүнд 8084 сэтгэл буй гэдэг. Ийм олон сэтгэл хүнд байдаг гэхээр гайхмаар... Түүний дотроос муу сэтгэлийн адгийн нь уур, мунхаг, шунал болой. Үр үндэс нь нүгэл хилэнц ажээ. Гэхдээ эмтэрсэн сэтгэл засардаг. Хүнд 404 өвчин тусдаг гэж уламжлалт анагаах ухаан үздэг. Үүнээс 100 нь эм тан, элдэв заслаар бус сэтгэл санаагаар эдгэрдэг байна. Ерөндөг нь ердөө л эв зетэй харилцаа, эерэг зөөлөн уур амьсгал, зөв үйл, зүйтэй үгс ажээ. Үүнийг орчин үеийн анагаах ухаанд үгэн эмчилгээ буюу сэтгэл заслын эмчилгээ гэдэг. Энэ нь сэтгэлийн хүчийг нэмж, өвчнийг илаарьшуулж байгаа хэрэг.

Хүнд сайн муу хоёр сэтгэл хослон оршиж, сөргөлдөн тэмцэхдээ зөв сэтгэл давамгайлсаар иржээ. Хүний сэтгэлийг зөвтгөх, муутгах нь хүрээллийн хүмүүсээс их хамаарна. Жишээлбэл: Мөс шиг хүйтэн үг чулуудвал сэтгэлийн ир нь мохож элэгдэнэ, сайхан үг хэлбэл ирлэгдэж, урам зориг орно. “Сайхан үг сарын хүнс” гэдэг ардын үг бий. Хүн сэтгэлээрээ, шувуу жигүүрээрээ амьдарна.

Сэтгэлийн хүч чухам хаанаас гарна вэ? Юунаас сульдана вэ? “Сэтгэл баярлахаасаа гомдох нь, жаргахаасаа зовох нь, уярахаасаа хатуужих нь, тэнийхээсээ явцуурах нь, дэвтэхээсээ хагсах нь, сэргэхээсээ сэвтэх нь сэтгэлд илүү хүч тэнхээ өгнө” гэж зохиолч Д.Урианхай дүгнэжээ. Сэтгэлийн хүчээ байнга цэнэглэж байх аваас зовлонг дааж, жаргалд ташуурахгүй тэгш амьдрахын үндэс болно.

Сэтгэл нь галтай, итгэл нь хүчтэй, муу санаагүй, мунхаг ухаангүй бол гэгээн, гэрэлтэй, сэтгэлийн тэнхээтэй хүн дээ.

Д.Баттогтох

1. Эхэд буй үгсийг утгатай нь зөв тохируулаарай.

- | | |
|-------------|-------------------------------|
| 1. туухай | a. тамир тэнхээ |
| 2. жин | b. муу юмыг номхотгон дийлэгч |
| 3. ерөндөг | c. хүнд, хөнгөний хэмжүүр |
| 4. харимхай | d. буцааж татах чанар |
| 5. бяд | e. хэмжээтэй төмөрлөг зүйл |

A. 1b, 2c, 3e, 4a, 5d

B. 1e, 2c, 3d, 4a, 5b

C. 1e, 2b, 3c, 4d, 5a

D. 1e, 2c, 3b, 4d, 5a

E. 1d, 2a, 3b, 4e, 5c



2. Эсээний хөтөч санаа аль вэ?

- A. Хүн сэтгэлээрээ, шувуу жигүүрээрээ амьдарна.
- B. Сэтгэлийн хүчийг жингийн туухайгаар хэмжиж боломгүй.
- C. Сэтгэлийн хүчийг нэмж, өвчнийг илаарьшуулдаг.
- D. Хүч чадал гэхэд биеийн хүч, тамир тэнхээ л яригддаг.
- E. Хүнд байдаг илүү их хүч бол сэтгэлийн тэнхээ.

3. “Хүчтэй сэтгэл нь юуг ч хийнэ, бүтээнэ, дийлнэ” гэжээ. Тэгвэл сэтгэлийн хүчийг юу ирлэх вэ?

- A. зөв үйл
- B. элдэв засал
- C. эм тан
- D. сайхан үг
- E. сэтгэлийн бяд

4. Зохиогчийн үзэл бодол бүхий өгүүлбэрийг сонгоорой. Ингэхдээ дараах тодорхойлолтыг ашиглаарай.

Мэдрэмж	Дүгнэлт	Үзэл бодол
Таван мэдрэхүйд мэдрэгдсэн зүйл	Хурааж нэгтгэсэн баталгаа	Санаанд илрэх санал

- A. Санаа тогтворгүй, харимхай сэтгэлээс ажлын бүтээмж үл гарна.
- B. Мөс шиг хүйтэн үг чулуудвал сэтгэлийн ир нь мохож элэгдэнэ.
- C. Бурхны шашны үзэл номлолоор хүнд 8084 сэтгэл буй гэдэг.
- D. 100 нь эм тан, элдэв заслаар бус сэтгэл санаагаар эдгэрдэг байна.
- E. Сэтгэлийн хүчийг нэмж, өвчнийг илаарьшуулж байгаа хэрэг.

5. “Сэтгэлийн хүчээ ашиглавал хүндийг өргөж, хэцүүг давж, өвчнийг тэсвэрлэн эдгэрч чадна” гэсний учир юу вэ?

- A. Хүнд сайн муу сэтгэл хослон оршиж, сөргөлдөн тэмцдэг учраас
- B. Эерэг зөөлөн уур амьсгал, зөв үйл, зүйтэй үг нь сэтгэл засдаг учраас
- C. Орчин үеийн анагаах ухаанд сэтгэл заслын үгэн эмчилгээ ашигладаг учраас
- D. Сэтгэлд хүч тэнхээ, хурд, шид, нууц агуулагдаж байдаг учраас
- E. Хүний сэтгэлийг зөвтгөх муутгах нь хүрээллийн хүмүүсээс хамаардаг учраас

6. “Биеийн бөхөөр ганцыг дийлнэ, сэтгэлийн бөхөөр мянгыг дийлнэ” гэсэн санааг батлах нь аль вэ?

- A. Сэтгэлийн хүчийг жингийн туухайгаар хэмжиж боломгүй.
- B. Сэтгэлийн хүчээ зөв залбал чихээр сонсоогүйг сонсоно.
- C. Сэтгэлийн бядгүй бол буруу муу үйлд өртөнө.
- D. Сэтгэл рүү нь хүйтэн үг чулуудвал ир нь мошно.
- E. Сэтгэлийн хүчээр хүндийг өргөж, хэцүүг давна.

7. Сэтгэлийн хүчээ байнга цэнэглэснээр яах вэ?

- A. сэтгэлдээ сэвгүй байна
- B. жаргалд ташуурахгүй байна
- C. зовлонг дааж сурна
- D. тэгш амьдарна
- E. сэтгэл ирлэгдэнэ

8. Эсээнд ямар асуудлыг дэвшүүлсэн байна вэ?

- A. Зарим өвчин сэтгэл санаагаар эдгэрдэг тухай
- B. Сэтгэлийн хүчээ зөв залдаг байх тухай
- C. Сэтгэлийн бядгүй бол муу үйлд өртдөг тухай
- D. Хүнд сайн муу сэтгэл хослон оршдог тухай
- E. Сэтгэлийн хүч хэмээгчийн тухай



9. Гол санааг илэрхийлэх өгүүлбэр аль вэ?

- A. Сэтгэлд хүч тэнхээ, хурд, шид, нууц агуулагдаж байдаг нь маргаангүй үнэн.
- B. Сэтгэлийн хүчээ байнга цэнэглэж байх аваас зовлонг дааж, жаргалд ташуурахгүй тэгш амьдрахын үндэс болно.
- C. Хатгүй бол үг даахгүй санаагаар унахаас эхлээд шантарч, амьдралд сөхөрдөг.
- D. Хүнд сайн муу хоёр сэтгэл хослон оршиж, сөргөлдөн тэмцэхдээ зөв сэтгэл давамгайлсаар иржээ.
- E. Эмтэрсэн сэтгэл засардаг ба ерөндөг нь эв зетэй харилцаа, эерэг зөөлөн уур амьсгал, зөв үйл, зүйтэй үгс.

10. Аливаа зүйлийн мөн чанарыг аажмаар өсгөн дүрсэлж, хүч нэмэн ахиулсан ахиулал бүхий хэсгийг олоорой.

- A. Түүний дотроос муу сэтгэлийн адгийн нь уур, мунхаг, шунал болой. Үр үндэс нь нүгэл хилэнц ажээ.
- B. Хүчтэй сэтгэл нь юуг ч хийнэ, бүтээнэ, дийлнэ. Иймээс сэтгэлийн хүчийг жингийн туухайгаар хэмжиж боломгүй.
- C. Сэтгэлд хүч тэнхээ, хурд, шид, нууц агуулагдаж байдаг. Түүнийгээ ашиглавал хүндийг өргөж, хэцүүг давж, өвчнийг тэсвэрлэн эдгэрч чадна.
- D. Бурхны шашны үзэл номлолоор хүнд 8084 сэтгэл буй гэдэг. Ийм олон сэтгэл хүнд байдаг гэхээр гайхмаар...
- E. Хүнд сайн муу хоёр сэтгэл хослон оршихдоо зөв сэтгэл давамгайлсаар иржээ. Хүний сэтгэлийг зөвтгөх, муутгах нь хүрээллийн хүмүүсээс хамаарна.

11. “Хүч чадал гэхэд биеийн хүч, тамир тэнхээ л нэн түрүүнд яригддаг” өгүүлбэрийг салаалан хувиргасан нь аль вэ?

- A. Хүч чадал гэхэд тамир тэнхээ л нэн түрүүнд яригддаг.
- B. Хүч чадал гэхэд биеийн хүч, тамир тэнхээ л нэн түрүүнд яригддаг билээ.
- C. Хүч чадал гэхэд биеийн хүч л нэн түрүүнд яригддаг.
- D. Хүч чадал гэхэд, тамир тэнхээ, биеийн хүч л нэн түрүүнд яригддаг.
- E. Хүч чадал гэхэд биеийн хүч, тамир тэнхээ л хамгийн эхэнд яригддаг.

12. “Санаа тогтворгүй, үлбэгэр, **харимхай** сэтгэлээс ажлын бүтээмж үл гарна” өгүүлбэр дэх “харимхай” гэсэн үг аль үгтэй холбогдож, ямар утгаар орсон бэ?

- A. “сэтгэлээс” гэсэн үгтэй холбогдож, шинжийн утгаар
- B. “сэтгэлээс” гэсэн үгтэй холбогдож, чанарын утгаар
- C. “сэтгэлээс” гэсэн үгтэй холбогдож, харьяаны утгаар
- D. “үл гарна” гэсэн үгтэй холбогдож, чанарын утгаар
- E. “үл гарна” гэсэн үгтэй холбогдож, шинжийн утгаар

13. “Сайн муу хоёр сэтгэл сөргөлдөн тэмцэхдээ зөв сэтгэл давамгайлсаар иржээ” өгүүлбэрийг зөв тодорхойлсон нь аль вэ?

- A. Шууд тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- B. Шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- C. Байц гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- D. Тодотгол гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр
- E. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр

14. “Сайхан үг хэл**бэл** урам зориг орно” өгүүлбэрийг цагийн утгатай болгоход аль нөхцөл тохирох вэ?

- A. -ээд
- B. -хлээр
- C. -сээр
- D. -мэгц
- E. -ж



15. “Мунхгийн уур нь хулганад тарваганы хавх зүүхэд хүргэдэг” өгүүлбэрийн “мунхгийн” хэмээх үг ямар үгсийн аймгийн үүргээр орсон бэ?

- A. төлөөний үгийн B. тооны нэрийн C. орон цагийн нэрийн
D. жинхэнэ нэрийн E. тэмдэг нэрийн

16. Идэвхгүй язгуураас бүтсэн үгийг олоорой.

- A. **ооно** шаргачин B. унь **тооно** C. алба **хаана**
D. үнээ **саана** E. голын **цаана**

17. “өмд” хэмээх үгийг нутгийн аялгуутай нь зөв харгалзуулсныг олоорой.

- a. маяг 1. казак
b. дамбаалаа 2. урианхай
c. үмдэн 3. хорь буриад

- A. a2, b1, c3 B. a1, b3, c2 C. a3, b1, c2 D. a2, b3, c1 E. a3, b2, c1

18. Бүлэг үгийн бүтээврийн үүргийг ажиглаад, дарааллаараа тохирохыг сонгоорой.

<i>доголон</i>	<i>уран</i>	<i>гүдэн</i>
<i>салан</i>	<i>өдөн</i>	<i>довон</i>
<i>хайлан</i>	<i>тарган</i>	<i>овон</i>
.....		

- A. хурдан, хавтан, шаналан B. хурдан, шаналан, хавтан
C. шаналан, хавтан, хурдан D. хавтан, шаналан, хурдан
E. шаналан, хурдан, хавтан

19. Дутагдан холбох нөхцөлтэй хэсгийг олоорой.

- A. Бодоод бодоод бодын шийр дөрөв.
B. Өөхөнд ороовч нохой шиншихгүй.
C. Өнгөнд унавал хөрөнгө хөнөөлтэй.
D. Хаагаа ханзартал, ханцуйгаа тасартал.
E. Хумсалсаар хумсалсаар хулгайч.

20. “Сайхан газар луу **яв+сан+ыг** нь **сонс+чих+оор** давхиад очмоор санагдах юм” өгүүлбэр дэх бүтээврийн нийлцийг зөв бичсэн нь аль вэ?

- A. явсныг, сонсчихоор B. явасныг, сонсчихоор C. явсаныг, сонсчихоор
D. явсаныг, сонсчхоор E. явсныг, сонсчихоор

21. “Эгшигт гийгүүлэгчийг зөөлрүүлсэн “ь”-ийн дараа заримдаг гийгүүлэгч орвол “ь” хэвээр байна” дүрэмд тохирох үгийг сонгоорой.

- A. томьёо B. барьц C. завьяа D. овьёос E. хавьгүй

22. Л.Өлзийтөгсийн “Аквариум” өгүүллэгийн гол санааг зөв нөхөөрэй.

Орчин цагийн хот суурин газрын хүмүүс өөрсдийгөө дөрвөн ханан дунд хорих нь яг л шилэн хоргонд хоригдсон баатрын нэг адил орчноо мэдрэх нь, эрх, эрх чөлөө нь ч ажээ.

- A. хагас дутуу, хязгаарлагдмал B. хагас дутуу, зах хязгааргүй
C. дутуу дулимаг, нуугдмал D. дутуу дулимаг, нээлттэй
E. өчүүхэн бага, хавчигдмал

23. Л.Өлзийтөгсийн “Аквариум” өгүүллэгийн “Би охиноо хэмжээлшгүй ихээр өрөвдөж байлаа. Гэвч загас бол загас шүү дээ. Тэр ярьж чадахгүй. Ярилаа гэхэд та бод доо, хэн нэгнийг өрөвдөж байгаагаа хэллээ, ярилаа, илэрхийллээ. Тэгээд? Тэгээд л болоо” хэсэг зохиомжийн аль бүрэлдүүлбэрт хамаарах вэ?

- A. хөрөг дүр B. зохиолчийн тэмдэглэл C. харилцан яриа
D. хүүрнэл яриа E. дотоод яриа



24. Л.Түдэв “Оройгүй сүм” романы “Андуу, Төвөдийн орноо хүрэх замын хамгийн хөлтэй хотын нэг нь болох өөлдүүдийн амьдардаг Алшаа яаманд монголчууд бууж, татвар төлж, хоол хүнс сэлбэж, наймаа хийдэг заншилтай болой. Өөлдийн хошууг анх Чин ван Лувсандорж гэгч зуу гаруй жилийн өмнө байгуулан захирчээ” хэсэгт ямар хам сэдэв дүрслэгдсэн байна вэ?

- А. Андуу Төвөдийн орон, Алшаа яам, Өөлдийн хошуу” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул соёлын
- В. “татвар төлөх, хоол хүнс сэлбэх, наймаа хийх” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул нийгмийн “
- С. “Андуу Төвөдийн орон, Алшаа яам, Өөлдийн хошуу” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул шашны
- Д. “татвар төлөх, хоол хүнс сэлбэх, наймаа хийх” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул улс төрийн
- Е. “Чин ван Лувсандорж, Өөлдийн хошуу, зуу гаруй жилийн өмнө” зэрэг үг хэллэгээр илэрсэн тул түүхийн

25. Л.Түдэв “Оройгүй сүм” романы “Тэнгэр, асар, хүн, адгуусны төлөө ч мөргөн залбирч болох юм. Гэтэл бирд, тамын орныхны төлөө яагаад сүжиглэдэг билээ?” гэсэн Санжийн бодлоос дүрийн ямар зан араншин илэрч байна вэ?

- А. салхин дэвүүр шиг
- В. дотор нь арилсан
- С. толгой даасан
- Д. санаа нь үзүүргүй
- Е. битүү морь шиг

26. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжигт:

“Олон онд дэгдээхэй байсан ч
Одоо тэр тас боллоо...” гэхэд
“Хажуугаар минь наад үгс чинь
Хийсэж байна” гэж хэлдэг. Энэ нь хэн хэний харилцан яриа вэ?

- А. Цэцэр, Арчугийн
- В. Гүргэл, Цэцэрийн
- С. Эгэрэг, Арчугийн
- Д. Эгэрэг, Гүргэлийн
- Е. Гүргэл, Арчугийн

27. Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжгийн

“Хүнийг төрхөө олоогүй байхад нь
Гөлгийг нүдээ нээгээгүй байхад нь төөрүүлдэг юм
Хааш хаашаагаа хаанд дарагдсаны
Хариуг авч бахаа хангамаар байна” хэсгээс дүрийн дотоод орчныг тодорхойлно уу.

- А. өширхөж хонзогносон
- В. дооглон доромжилсон
- С. зэмлэн шүүмжилсэн
- Д. буруутгаж шийтгэсэн
- Е. тоглон тохуурхсан

28. Ц.Чимиддорж “Сэлбэ” шүлгийн

“Тогтоол зарлиг дундуур урсаж байгаа хотын номхон голыг
Тогтоож чадалгүй уурга чирүүлэн алдсан байж” шад дахь “**тогтоол зарлиг**” хэмээх үгийг өөр үгээр солин найруулбал оновчтой нь аль вэ?

- А. тогтсон дүрэм
- В. тушаал шийдвэр
- С. тунхаг бичиг
- Д. тоот тушаал
- Е. тулган шаардлага

29. Ц.Чимиддорж “Сэлбэ” шүлгийн

“Уулсынхаа элгэнд хярж байгаа
Ухаан гуйн залбирч байгаа
Шидэмс шиг гол нэг л үүрээр
Шивнээ нь тасарч, амьсгалаа өвөр дээр чинь хураах нь ээ” бадгийн холбоцыг тодорхойлоорой.

- А. сөөлжүүлэх холбоц
- В. салаавчлах холбоц
- С. хаших холбоц
- Д. тэгш холбоц
- Е. зэрэгцэх холбоц



30. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж, тодорхойлолтыг гүйцээгээрэй.

Зохиолын үйл явдал өрнөх, дүрүүдийн амьдрах цаг үеийн нөхцөл байдал болон дүрүүдийн хоорондын харилцааны уур амьсгалыг тодруулсан байдал нь болно.

- A. зохиолын нөхцөл В. гадаад орчин С. орчин нөхцөл
D. дотоод орчин E. зохиолын зохиомж

31.


مصدقہٴ شہادت

॥ श्री गणेशाय नमः ॥
 श्री गणेशाय नमः ॥
 श्री गणेशाय नमः ॥
 श्री गणेशाय नमः ॥

- A. Хилийн гэрээг 1975 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага албан ёсоор бүртгүүлсэн.
- B. Хилийн гэрээг 1965 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн.
- C. Хилийн гэрээг 1975 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад албан ёсоор бүртгэсэн.
- D. Хилийн гэрээг 1975 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн.
- E. Хилийн гэрээг 1965 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад албан ёсоор бүртгэсэн.

32.

مصدقہٴ شہادت ..



- | A. | B. | C. | D. | E. |
|-------|--------|---------|------|--------|
| уран | уран | уран | орон | орон |
| санаа | сайхан | сийлбэр | сүүц | судлал |

33.

...مستحسن
محلل
محلل
محلل

- A. 
- B. 
- C. 
- D. 
- E. 

34.

- A. 
- B. 
- C. 
- D. 
- E. 

35.

مستندتیں :
 فیصلہ صادر
 لاخمس
 اس کا مکمل نسخہ

- A. 
- B. 
- C. 
- D. 
- E. 



36. << -хлээр >>
 Өмнөх нь хувь
 Өмнөх нь хувь
 Өмнөх нь хувь
 Өмнөх нь хувь
 Өмнөх нь хувь
37. Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
38. Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
39. Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
40. << бонзог >>
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь
 Өмнөх нь



ХОЁРДУГААР ХЭСЭГ

- Энэхүү хэсэг нь 3 даалгавар, нийт 20 оноотой.
- Харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Хэлц ба хэлц бус өгүүлбэрийг жишээтэй нь харгалзуулаарай. (a, b, c, d, e, f мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2 дугаарт байгаа нэр томьёо давхцаж болно.)

a. Энэ юу л бол доо. Ус үзэлгүй гутал тайлж, юмны түрүүнд хэрэг ч үгүй хэлж орхив уу даа. b. Айхавтар гар чангатай ах дүү хоёр байлаа. Адалж хүмүүс тэднийг харамчийнхан гэдэг байлаа. c. Адуу хөөн үргэлж холхин, өргөн говийг туулах тийм амар хэрэг биш. d. Жав гуайн голтой байгаагийн ганцхан утга учир л түүнд байна. e. Нэг сэрвэл үүр хаяарч, чийг үнэртсэн хүйтэн салхи баруун хойноос үлээж байв. f. Нойтон сормуустай балчир чи минь юу идэх билээ.	1. Хэлц өгүүлбэр 2. Хэлц бус өгүүлбэр
--	---

2.2. Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романы дүрийг, хэлсэн үг хэллэгтэй нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e, f, g, h мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3 дугаарт байгаа дүр давхцаж болно.)

a. - Дамшиг минь идэх гээд эрхийгээ, долоох гээд долоовроо идчих вий дээ. b. - Чи намайг загнадаг байсан, тийм үү? Одоо загнаж чадахгүй. Хэрэв чи загнавал би Дорж гуайд хэлж орхино. c. - Шувуунд нисэж яваад үхэх сайхан гэдэг. Надад ингэж яваад үхэх сайхан. d. - Чоно хонь барьж байхад салгадаг байхад хүн барих гэж байхад салгахгүй яах вэ. e. - Цаана чинь ядарсан монгол ах дүү нар байхад хуваагаад идэж болох нутгийг харамлах хэрэггүй юм шүү, Итгэлт минь. f. - Алтан нар шиг гялалзаж, мөнгөн сар шиг мэлтэлзэж байна даа. Эзэн минь, төрийн сүлд минь. g. - Би ардын засгийн ачаар саах үнээтэй, унах морьтой, идэх хоньтой болсон. h. - Яг л ирэх зуны дунд сарын арван наймны сар гарах үед би дөрвөн хос морьтой энд зогсож байна.	1. Төмөрийн үг 2. Нямаагийн үг 3. Галсангийн үг
---	---

2.3. Үгсийг дүрсээр ялган, утгатай нь зөв тохируулаарай. (a, b, c, d, e, f мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 дугаарт байгаа үгс давхцаж болно.)

a. хөөр (баяр)	1.	2.	3.	4.
b. хөөр- (дээш)	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ
c. хөөр- (ярих)	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ
d. хүр (хорхой)	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ
e. хүр- (үйл үг)	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ
f. гөр- (гээг)	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ	ᠬᠡᠭᠡᠷ

